



# ЦЭНХЭР АЛТ

ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ УСНЫ ГАЗРААС ЭРХЛЭН ГАРГАВ.

2021.VII CAP

## ХҮНД БУЯН ХИЙЕ ГЭВЭЛ ТАРХИНД НЬ МЭДЛЭГ ТОГТОО БАЙГАЛЬД БУЯН ХИЙЕ ГЭВЭЛ ХЭВЛИЙД НЬ УС ТОГТОО



*Усны газраас ажлын хэсэг гарч Сэлэнгэ аймгийн Баянгол, Дархан-Уул аймгийн Шарын гол сумдын нутагт уул уурхайн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллагуудын ус ашиглалтын байдалтай газар дээр нь танилцаад ирлээ. Усны тухай хууль, Ус бохирдуулсаны төлбөрийн тухай хууль, тэдгээрт нийцүүлж гаргасан дүрэм журмын хэрэгжилтийг хянаж шалгах энэхүү ажлын хэсгийг Усны газрын Ус ашиглалтын хэлтсийн дарга, ХУ-ны доктор Х.Шүрэнцэцэг ахалж явсан юм. Энэхүү ажлын хэсэгт тус хэлтсийн ахлах мэргэжилтэн Б.Дарханчимэг, Усны нөөцийн хэлтсийн мэргэжилтэн Б.Гантогтох, Усны хяналт-шинжилгээний хэлтсийн мэргэжилтэн Д.Мөнхзул, жолооч П.Пүрэвсүрэн нар баг болон Хараа-Ерөө голын сав газрын захиргаатай хамтран ажилласан юм.*

*Энэхүү ажлын хэсгийн ахлагч Х.Шүрэнцэцэгтэй уулзаж ярилцлаа.*

**-Уул уурхайн үйл ажиллагаа явуулж байгаа ямар ямар газруудаар явав? Зөрчил дутагдал их байна уу?**

Бид Сэлэнгэ аймгийн Баянгол, Дархан-Уул аймгийн Шарын гол сумдын нутагт томилолтоор ажиллаад ирлээ. “Жамп алт” ХХК-ийн нөхөн сэргээлт хийсэн талбай, “Пентатерра” ХХК-ийн Наран голын зүүн дэнжийн алтны шороон ордны ашиглалтын талбай, “Грийн пид” ХХК-ийн хайгуулын талбай, Шарын гол сумын Хар морьт нэртэй газар үйл ажиллагаа явуулж буй “Минж энэрэх наран” нөхөрлөлийн нөхөн сэргээлтийн талбай, Буянт голын голидрол дагуу “ЧЧБТХ” ХХК-ийн үйл ажиллагаатай танилцлаа.

Орон нутгийн иргэд нөхөрлөл нэрээр алт олборлох, ус ашиглуулах дүгнэлт гаргуулалгүйгээр үйл ажиллагаа явуулах, газар дээрээ заавал байлгах баримт бичгийн бүрдэлгүй, усны эх үүсвэрийн онцгой болон энгийн хамгаалалтын, эрүүл ахуйн бүсийн дэглэмийг зөрчиж байгаа зэрэг зөрчил, дутагдлууд байна.

**- Зөрчилтэй үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжүүдэд ямар арга хэмжээ авч байна вэ?**

Олборлолт явуулж

буй тусгай зөвшөөрлийн талбай нь усан сан бүхий голын эргээс 22-35 метрт байгаа юм. Буянт голын голдиролд бичиг баримтгүй үйл ажиллагаа явуулж байсан аж ахуйн нэгжид Хараа-Ерөө голын Сав газрын захиргааны ахлах мэргэжилтэн, Байгаль орчны хяналтын улсын байцаагч зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны тэмдэглэл газар дээр нь үйлдэн, Сэлэнгэ аймгийн прокурорт мэдүүлэхээр ажиллаж байгаа. Усны сан бүхий газар, усны эх үүсвэрийн онцгой болон энгийн хамгаалалтын, эрүүл ахуйн бүсийн дэглэмийг мөрдүүлэх шаардлагыг аймгийн ЗДТГ, аймгийн мэргэжлийн хяналтын газарт хүргүүлж байна. Бичиг баримтгүйгээр үйл ажиллагаа явуулж байсан аж ахуйн нэгжүүдийг Экологийн цагдаагийн албанд мэдэгдээд байгаа.

**- Усны бохирдлын түвшинд үнэлгээ дүгнэлт өгөв үү?**

- Тийм ээ. Бид Голын усны бохирдлын түвшинд үнэлгээ дүгнэлт өгөх зорилгоор Наран, Шаазгайт, Шарын голын уснаас сорьц авч Цаг уур орчны шинжилгээний харьяа Байгаль орчин хэмжил зүйн төв лабораторид хүргүүлж, хариуг авсан байгаа. Энэхүү шинжилгээний дүнг MNS



*Багийн бүрэлдэхүүн*

4586:1998 Усан орчны чанарын үзүүлэлт. Ерөнхий шаардлага стандарттай харьцуулахад бичил элемент Зэс ( $\text{Cu}^{2+}$ )-ээс бусад физик-химийн үзүүлэлтүүдээр тус стандартын шаардлагыг хангаж байсан. Голын усны чанарын үзүүлэлтээр стандартын шаардлагыг хангаж байгаа хэдий ч органик бодисын задралын дүнд үүсдэг азотот нэгдлүүд болох  $\text{NH}_4^+$ ,  $\text{NO}_3^-$ ,  $\text{NO}_2^-$ ,  $\text{P}_{\text{эрдэс}}$  бага хэмжээгээр илэрсэн нь голын хамгаалалтын бүсийн ойролцоо уул уурхайн үйл ажиллагаа явуулснаар хөрсний агаар, усны солилцоо буурч, ангижрах процесс явагдан хүний үйл ажиллагааны нөлөөгөөр бохирдож буйг илтгэж байна. Мөн эрдэсжилт, гол ионуудын хэмжээ бага байгаа нь бидний томилолтоор ажилласан цаг хугацаатай давхцан олон хоногоор хур тунадас орсон байснаас голын усны найрлага шингэрсэн байх боломжтой юм. Нарангийн голын эх, Шарын голын цутгал Шаазгайт голын ус нь байгалийнхаа унаган төрхөөрөө байгаа цэвэр, тунгалаг,

уулын цэнгэг гол хэдий ч уул уурхай, хүний үйл ажиллагаанд өртсөн хэсгээс эхлэн булингартай болж голын усны чанар ургынхаа дагууд өөрчлөгдөж байна.

***-Та усны салбартай хэзээ анх холбогдсон бэ?***

ОХУ-ын Москва хотод их сургууль төгсөхдөө 20 жилийн өмнө дипломын ажлаа Москва голын усны чанарын судалгаагаар хийж байлаа. Тэгэхлээр тэр үеэс л холбогдсон гэж үзэж болох байх. Их сургуулиа төгсөж ирээд Нийгмийн эрүүл мэндийн хүрээлэнгийн Орчны эрүүл мэндийн судалгааны секторт эрдэмтэн багш нарынхаа шавь болж эрдэм шинжилгээний ахлах ажилтан, секторын эрхлэгч, эрдэмтэн нарийн бичгийн дарга хүртлээ дэвшиж 12 жил энэ байгууллагадаа усны чиглэлээр ажилласан. 2009 онд ОХУ-ын Иваново хотын Хими технологийн Их сургуульд “Ундны ус бэлтгэх технологийн үед усны чанар өөрчлөгдөх нь” сэдвээр Химийн ухааны дэд докторын

зэргийг хамгаалсан. Шинжлэх ухаан технологийн болон гадаад, дотоодын 30 гаруй судалгааны ажилд оролцож, 60 гаруй эрдэм шинжилгээний өгүүлэл, илтгэл, 20 орчим гарын авлага, ном хэвлүүлсэн бөгөөд ихэнх нь усны чиглэлээр байдаг юм.

***-Байгаль орчин, аялал жуулчлалын яаманд нэлээд хэдэн жил ажилласан байх. Тэнд байхдаа ямар даацтай ажлуудыг хийж гүйцэтгээ бол?***

2014-2017 онд “Монгол Ус” ТӨҮГ-ын Ерөнхий инженерээр, 2017-2020 онд Байгаль орчин, аялал жуулчлалын яаманд мэргэжилтнээр, 2020 оноос хойш Усны газарт Ус ашиглалтын хэлтсийн даргаар ажиллаж байна. БОАЖЯаманд ажиллах хугацаандаа “Гадаргын усны чанарыг бохирдлын индексээр үнэлэх заавар” БОАЖСайдын А/332 дугаар тушаал, “Ус ашиглагч иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь ахуйн бохир ус зайлуулах цэгээ ус тусгаарлагчаар тусгаарлаж тохижуулах журам” БОАЖС, ЭМС-ын хамтарсан тушаал, “Зөвшөөрсөн хэмжээнээс илүү ашигласан усны төлбөр тооцох журам” зэргийг боловсруулж, батлуулсан нь байгалийн нөөцийг хэмнэлттэй ашиглаж, хомсдохоос сэргийлэх, усны нөөцийн зохистой хэрэглээг бий болгоход чухал хөшүүрэг болсон гэж үзэж байгаа.

Ус бохирдуулсны төлбөрийн тухай хууль 2012 онд анх батлагдсан боловч хэрэгжээгүй байсан энэ хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулах ажлын хэсэгт ажиллаж, холбогдох судалгааны тайлангуудыг



*Наран голын эхээс дээш нөхөн сэргээлт хийсэн талбайд нинжа нарын ухсан газар*



боловсруулсан нь УИХ-ын нэгдсэн чуулганаар хэлэлцэгдэж, батлагдан 2020 оноос хэрэгжиж эхлээд байна.

“Усны тухай” хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулах ажлын хэсэгт ажиллаж, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг “Усны газар”-ыг дахин байгуулах эрхзүйн орчинг бүрдүүлэхэд тодорхой хувь нэмэр оруулах аз тохиосон юм.

***-Ус ашиглалтын хэлтсийн даргын хувьд хэдэн зүйл асууя. Бидний монголчууд усаа ашиглах, зөв гамтай хэрэглэх тал дээр ямар ахиц, дэвшил гараасай гэж боддог вэ?***

Манай улс жилд 590 орчим сая. м<sup>3</sup> ус ашиглаж байна. Ус ашиглалтын хэлтсийн хувьд хоногт 100 шоометрээс дээш ус ашиглагчдад буюу 200 гаруй аж ахуйн нэгжид ус ашиглуулах дүгнэлт гаргаж, усны нөөц ашигласны төлбөрийг ногдуулж байгаагаас гадна, Сав газрын захиргаад, аймаг, нийслэлийн байгаль орчны газруудын гаргасан 500 орчим аж ахуйн нэгжийн ус ашиглуулах дүгнэлтийг хянаж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, улсын хэмжээнд ус ашиглалтын тоо мэдээллийг нэгтгэж, тайлагнаж байна.

Усыг зөв зохистой хэрэглэх, ашиглах тал дээр ахиц дэвшил гарч байгаа хэдий ч усыг эргүүлэн болон дахин ашиглах чиглэлээр аж ахуйн нэгжүүд санаачлагатай ажиллах, нөгөө талаас хууль эрхзүйн орчинг бүрдүүлэх шаардлагатай байна. Өөрөөр хэлбэл, ус ашиглагч, хэрэглэгч, төлөвлөгч, бүх шатны бодлого боловсруулагч нарын харилцан уялдаатай хамтын ажиллагаа чухал байна.

Судалгаагаар манай улсад 2019 оны байдлаар ус ашиглалтын үр ашиг 26012 төгрөг/м<sup>3</sup> байна. Ус ашиглалтын үр ашгийн тооцооллын

үр дүнгээс үзэхэд манай улсын усны нийт хэрэглээний 60% зарцуулдаг хөдөө аж ахуйн салбар ашигласан 1м<sup>3</sup> ус тутамдаа дөнгөж 1814 төгрөгийн нэмүү өртөг бүтээж байна. Энэ нь хөдөө аж ахуйн салбарын ус ашиглалтын үр ашгийг эрс нэмэгдүүлэх зайлшгүй шаардлагатайг харуулж байна л даа.

***-Ус ашиглалтын хэтийн төлөвийн талаар та бүхэн ямар бодлого баримтлан ажиллаж байна вэ?***

Монгол улсын усны нөөц нь нутаг дэвсгэрийн хувьд хэтэрхий жигд бус хуваарилагдсан, гадаргын усны дийлэнх хэсэг нь гадагш урсаад гардаг, уулархаг бүс нутгийн усны нөөц нь хур тунадасаар дамжин богино хугацаанд нөхөн сэргээгдэж чаддаг зэрэг онцлогтой. Эдгээр онцлогт тохирсон арга хэмжээнүүдийн нэг нь нутгийн хойт хэсгийн голуудад урсцын тохируулга хийх замаар усны нөөцийг нэмэгдүүлэх, хорогдож бохирдохоос хамгаалах зүй зохистой ашиглах явдал юм.

Цаашид говийн бүсэд уул уурхайн хөгжил дагасан, төвийн болон баруун, дорнод бүсэд газар тариалан, эрчимжсэн мал аж ахуйн үйлдвэрлэлийн хэрэгцээний, хот суурин газруудад шинээр орон сууцжуулалт нэмэгдэх, амьдралын орчин нөхцөл сайжрах, хөнгөн ба хүнсний үйлдвэрлэл, жижиг дунд бизнес хөгжихтэй уялдан усны

хэрэглээ-ашиглалт өсөх болно.

2030-2040 оны хэмжээнд Монгол улсын хэмжээнд нийт ус хэрэглээ 1500-2000 сая м<sup>3</sup>/жил (1.5-2.0 км<sup>3</sup>/жил) буюу их өсөлттэй тохиолдолд одоогийн ус хэрэглээ 3-4 дахин өсөх төлөвтэй байна. Энэ хэмжээ нь манай орны ашиглах боломжтой нөөцийн 10-20 орчим хувь болох юм. Манай улс ирээдүйн ус хэрэглээний хэтийн төлөвийг хангах хангалттай усны нөөцтэй байгаа юм шиг боловч газар зүйн бүс нутгуудад харилцан адилгүй тархсан байдаг нь л ирээдүйн ус хэрэглээг хангахад хамгийн их хүндрэлийг бий болгож байгаа юм.

Энэ бүх өсөн нэмэгдэх усны хэрэглээ-ашиглалтыг одоо байгаа газрын доорхи болон гадаргын усаар хангах боломж үндсэндээ байхгүй учраас усны нөөцийг нэмэгдүүлэх зайлшгүй шаардлага бидэнд тулгарах болно. Эдгээр өсөлтийн дийлэнхийг Хойд мөсөн далайн ай сав, Сэлэнгэ мөрний ус хураах талбайн ашиглах боломжтой нөөцөөс хангах нь хамгийн зөв шийдэл юм.

***-Танд устай холбоотой эрхэмлэн санаж явдаг ямар үг байдаг вэ?***

“Хүнд буян хийе гэвэл тархинд нь мэдлэг тогтоо

Байгальд буян хийе гэвэл хэвлийд нь ус тогтоо” гэсэн үг их ойрхон байдаг.



## ЗУУН НАСТАЙ УСЖУУЛАГЧ



Долгорын Ёндондүйчир нь 1921 оны 04 дүгээр сарын 10-нд Өвөрхангай аймгийн Зүүнбаян-Улаан сумын 1 дүгээр багийн нутаг “Бамбахай” гэдэг газар жирийн малчны гэр бүлд төрсөн. Одоо 100 насыг наслаад Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүргийн нэг дүгээр хороололд амьдран сууж байна. Бага насаа мал маллаж өнгөрүүлсэн түүнд нэг голын багын найз генерал Ёндондүйчир хамт сургуульд явахыг санал болгожээ. Улмаар Өвөрхангай аймгийн цэргийн хэлтэст шалгалт өгөөд найз Ёндондүйчир нь цэргийн сургуульд орж, өөрөө мал эмнэлгийн сургуульд орсон байна.

Тэрбээр 1939 онд Улаанбаатар хотын Мал эмнэлгийн сургуульд

зоотехникчийн ангид элсэн орж анх бичиг үсэг / хуучин монгол бичиг/ сурч улмаар мэргэжлийн дагуу суралцаж байгаад, 1941 оны намар ээж нь өвдөж, ар гэрийн гачигдлаар эргэж сургуульдаа явж чадаагүй ажээ.

1942 оны хавар Ардын армид цэрэгт тагагдан Улаанбаатар хотын их бууны дивизионд түгээгч цэрэг байгаад, 1943 оны сүүлчээр Цэргийн ерөнхий сургуульд сурагчаар элсэн суралцан төгссөн аж. Улмаар 1945 оны намар их бууны тусгай хороонд салааны даргаар хуваарилагдсан байна. 1945-1947 онд Сайншандын цэргийн ангид салааны дарга, 1947-1951 онд Хэнтий аймгийн цэргийн ангид салаан даргаар алба хааж байсан. Цэргийн албанд ажиллах хугацаанд Төв аймгийн Мөнгөнморьтоос Хэнтий аймгийн төв хүртэл Хэрлэн голоор талдаа 950 км газар 31 удаа цэргийн арын албанд салаар мод татаж байсан нь түүний устай холбогдсон анхны ажил байв. Улмаар 1951 онд ахлах дэслэгч цолтой бэлтгэл офицероор цэргийн албанаас халагдсан байна.

Тэрбээр 1952 оны хавар Хөдөө аж ахуйн яамны Усны хөгжлийн хэлтэст ажиллаж эхлэн, салбарын харьяа Сэлэнгэ аймгийн Цагаан толгойн САА-н услалтын системд аж ахуй, санхүүг хариуцан ажиллаж байгаад 1955 оны тавдугаар сараас Усны Аж Ахуйн газрын дарга Чогдон, ерөнхий инженер Должинжав, Дамба,

Барс, Доржпалам, Диваадэмбэл нарын удирдлагад гүний худгийн өрөмдлөгийн өрмийн мастерын 45 хоногийн курст суралцаж **Ахлах мастер** мэргэжил эзэмшсэн байна.

Д.Ёндондүйчир нь Усны аж ахуйн салбарт Монгол орны байгаль, цаг уурын эрс тэс нөхцөлд төв суурин газар болон говь, тал, хээрийн бэлчээр нутгийг усжуулах үйл хэрэгт залуу насныхаа 26 жилийг зориулж, гүний өрөмдмөл худаг гаргах ажлыг хийн гүйцэтгэж иржээ. 1955 оноос хамгийн анх Өмнөговь аймгийн Баян-овоо сумын зүүн хэсэг, Цогтцэций, Манлай, Ханбогд сумын Бунхан тал гэдэг зэлүүд өргөн уудам бэлчээрт элбэг устай өрөмдмөл худаг гаргаснаар ажлын гараагаа эхлүүлснээс 1963 он хүртэл 7 аймагт 28 гүний худаг гаргасан байна. Түүний гаргасан гүний худгууд Монголын анхны өрөмдмөл худгуудын жагсаалтад бичигдсэн байдаг. Гүний худгийг 35-150 м өрөмдөж байсан буюу нэг худгийн дундаж гүн 70-75 м орчим байсан байна. 1960 онд гүн өрөмдлөгийн аварга бригад цол авч, тэр амжилтаа /1961 оноос - 1966 он хүртэл/ 5 жил дараалан 112,6-145,5%-иар давуулан биелүүлэн ажилласан байна. Түүний ажлын арга туршлага, амжилтыг төв орон нутгийн хэвлэл, мэдээллийн хэрэгслээр олон удаа сурталчилж байсны дотор “Усны үнэр” кино журналын гол баатар болгон бичигдэж байжээ.

Улмаар Д.Ёндондүйчир нь 1963-1970 онд Төв аймгийн Усны аж ахуйн конторт ажиллах хугацаандаа сумдын төв болон бэлчээр нутагт 46 гүний өрөмдмөл худаг гаргасан нь төв суурин болон бэлчээрийг усжуулах үйл хэрэгт томоохон үүрэг гүйцэтгэсэн ажил болсон юм. Төв аймгийн Усны аж ахуйн конторт ажилаж байх хугацаанд **Улаанбаатар Оргил рашаан** худгийг гаргасан нь одоо болтол ашиглаж рашаан сувилал ажилласаар байна.

Мастер Д.Ёндондүйчир 1970-1975 оны хооронд Усны аж ахуйн яамны харьяа Усны аж ахуйн газар, Улаанбаатар хотын Зам далан суваг ашиглалтын конторт өрөмдмөл



худаг засварын группийн даргаар ажилласан байна. Энэ хугацаанд Улаанбаатар хотын дүүрэг, цэргийн анги, САА, рашаан сувилал, үйлдвэр аж ахуйн газруудын өрөмдмөл худгийн засварын ажлыг эрхлэн нийтдээ 61 өрөмдмөл худаг засварлажээ.

1975 онд Өрөмдмөл худаг засварын группийг Ус сувгийн удирдах газарт шилжүүлсэнтэй холбоотойгоор тус газрын станцуудын 75 орчим гүний худгийг засварлаж лайдах ажлыг хийж гүйцэтгэн ажиллаж байсан. Ус сувгийн удирдах газрын өрөмдмөл худаг засварын группийн даргын ажлыг хийж байгаад 1977 оны нэгдүгээр сард өндөр насны тэтгэвэрт гарсан. Одоо Ус сувгийн удирдах газрын хамгийн өндөр настан юм.

Д.Ёндондүйчир нь 75 гүний өрөмдмөл худаг гаргасан буюу нийт 6000 орчим ургааш метр урт өрөмдлөг хийж улсад хүлээлгэн өгч Монгол орны хот суурин, аж ахуй, үйлдвэрийн газар болон говь, хээр талд бэлчээр нутгийг усжуулахад зориулсан байна. Ардын хувьсгалтай нас чацуу, 100 насыг насалж зургаадай таяг тулсан ахмад усжуулагч танд эрүүл энх, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе.

### ШАГНАЛ:

1. “Бид ялав” медаль 1946 он
2. Засгийн газрын “Хүндэт үнэмлэх” 1956.12.30-нд
3. “Усны аж ахуйн тэргүүний усжуулагч “1963.12.24
4. БНМАУ-ын “Алтан гадас” одон 1961.03.19-нд
5. БНМАУ-ын “Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн” одон 1968.01.13-нд
6. БНМАУ-ын ҮЭ-ийн Төв зөвлөлийн “Хүндэт үнэмлэх” 1966.02.07-нд
7. БНМАУ-ын Ардын хувьсгалын 40, 70, 80 жилийн ойн медалиуд
8. Унгарын “Алтан-Од” медаль 1968.01.15-нд
9. Милитарист Японыг ялсны 30 жилийн ойн медаль 1976.02.05-нд
10. Ус сувгийн Удирдах Газрын “Чандмань Эрдэнэ” тэмдэг 2017.03.01-нд
11. Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын “Хүндэт тэмдэг” 2019.10.01-нд

### Д.Ёндондүйчир нь 1952 оны 03 дугаар сарын 01-ээс 1963 оны 05 дугаар сарын 05 хүртэл ажиллаж хөдөлмөрлөсөн үеийн ажлын бүтээл


Ажилласан он	Аймаг, хот	Гүний өрөмдмөл худаг гаргасан сум, нутгийн нэр	Гаргасан худаг	Усгүй цооног
1955 он	Дундговь	Хулд сумын Бор хонгорын зоо бэлчээр нутаг	-	1
1955 он	Өмнөговь	Баян Овоо сумын Бунхан талын бэлчээр	1	
1956 он	Улаанбаатар	Амгалан халуун ус, уурын зуух, Яармагт 5-р бааз	4	2
1956 – 1958 он	Баянхонгор	Байдраг сумын төв Баян хөндийн бэлчээр Байдраг сумын Могойн хөндийн бэлчээр Байдраг сумын урагш	1 1 1 1	1
1959 он	Өвөрхангай	Аймгийн төв Богд сумын төв Баруун баян Улаан сумын төв Төгрөг сумын төв Өндөр өнц сумын төв Гучин-Ус сумын Цагаан эрэг бэлчээр Төгрөг сумын Хонгорын зоо бэлчээр	1 1 1 1 1 1 1	1
1959 он	Улаанбаатар	Шувуун фабрик Налайх дүүрэг Био комбинатын үйлдвэрийн уурын зуух	2 1 1	
1960 он	Сэлэнгэ	Орхон туул сумын төв Цагаан толгой САА бэлчээр	1 1	
1961 он	Дорнод	Хэрлэн сумын төв Хэрлэн сумын бэлчээр Халх гол сумын бэлчээр Адуунчулууны уурхай Булган сумын бэлчээр	1 3 1	1 1
1962 он	Сүхбаатар	Түмэнцогтын САА-н тариа бригад Асгат сумын бэлчээр	1 1	
		<b>Өрөмдсөн худгийн тоо</b>	<b>28</b>	<b>7</b>

# УВС НУУР-ТЭС ГОЛЫН САВ ГАЗАР

## Увс нуур-Тэс голын сав газрын уур амьсгал, газарзүйн төлөв байдал онцлог.

Увс нуур-Тэс голын сав газар нь Монгол улсын хамгийн баруун хойд хэсэгт оршдог, Увс, Хөвсгөл, Завхан аймгийн 27 сумын нутаг дэвсгэрийг хамарсан 54 мянган км<sup>2</sup> талбай бүхий өргөн уудам нутаг юм.

Увс нуур-Тэсийн голын сав газар нь зүүн талаараа Дэлгэрмөрөн болон Идэр голын сав газруудтай, урд талаараа Хяргас нуур-Завхан голын сав газартай, баруун талаараа Хар нуур-Ховд голын сав газартай, хойд талаараа ОХУ-тай хиллэдэг. Увс нуур – Тэс голын сав газар нь эрс тэрс уур амьсгалтай мөнх цаст мөсөн уул, ой тайга, тал хээр, нуур ус, элсэн цөл зэрэг байгалийн бүх бүслүүр цогцолсон ховор ан амьтан, ургамлын өлгий нутаг дахин давтагдашгүй үзэсгэлэнт байгалтай дэлхийн өв нутаг юм. Нэн ховор болон ховор Аргаль, Ирвэс, Янгир, Буга, Зэрлэг гахай, Зэгсний гахай, Ондатор, Усны булга, Голын халиу, Сибирийн шивэр гүлмэр зэрэг ан амьтан Шинэс, Улиас, Бургас, Гацуур зэрэг мод бут элбэг.



Увс нуур нь олон улсын гео-биосферын судалгааны бүсэд багтдаг. Энэ дэлхийн байгалийн бүх бүслүүрийн бүхий л хэв шинж төрхийг өөртөө агуулсан эргэн тойрон уулсаар хүрээлэгдсэн нь энэ нутгийн олон улсын ач холбогдол бүхий төв азийн эталон нутаг болохыг илтгэж байна. Уур амьсгалын хувьд Сибирийн чийглэг тайгаас Төв азийн хуурай элс, цөлөрхөг бүсэд шилжих нарийн зурвас нутагт оршихын зэрэгцээ гадаад далайгаас ихээхэн алслагдаж эргэн тойрон өндөр уулсаар хүрээлэгдсэн байдаг. Энэхүү газарзүйн

онцлог нь манай орны уур амьсгалыг эх газрын эрс тэс, гандуу хуурай, мөн экосистем нь уур амьсгалын өөрчлөлтөд эмзэг байх гол нөхцөлийг бүрдүүлдэг. Уур амьсгалын өөрчлөлт, газрын гадарга орчмын агаарын жилийн дундаж температур дулаарч, улмаар жилд орох хур тунадасны хэмжээ буурсан нь гандах, хуурайших процесс эрчимтэй явагдаж байгааг харуулж байна. Бүс нутаг нь эх газрын хамгийн хатуу ширүүн уур амьсгалтай бөгөөд улирлын ялгаа тод илэрдэг. Жилийн дундаж болоод хүйтний улирлын агаарын температурын хувьд харгалзах өргөрөгийн бүст хамгийн хүйтэн, жилийн дундаж агаарын температур -8°C хүртэл хүйтэн, өвлийн хамгийн хүйтэн 1 дүгээр сарын дундаж температур нь -30-35°C, үнэмлэхүй хүйтэн нь -50°...-55.3°C (Увс аймгийн Зүүнговь суманд 1976 оны XII сарын 31-нээс 1977 оны 1 сарын 1-нд шилжих шөнө) хүрдэг. Их нууруудын хотгор бол манай орны хамгийн хуурай бүс нутгийн нэг ба бага хур тунадас унана.

Увс, Үүрэг нуур, Тэс, Хөндлөн, Торхилогийн голын эргээр ус намгархаг бөгөөд олон улсын ач холбогдол бүхий ус намгархаг газар, ялангуяа усны шувууд олноор амьдардаг орчны тухай конвенцид Увс нуур 2003 онд бүртгэгдсэн.

## УСНЫ НӨӨЦ

Ус зүйн сүлжээний хувьд сав газар бүхэлдээ төв азийн гадагш урсгалгүй ай савд багтдаг. Газарзүйн байрлалаараа Их нууруудын хотгорт оршдог. Энэ чанараараа гадаргын болон газрын доорх усаар баялаг.

Сав газрын 2014 оны усны тоо бүртгэлийн дүнгээр гол, горхи 256, нуур тойром 56, булаг шанд 445, рашаан 29, худаг 722, усалтын систем 16, усан сан 17, хөв 4, цөөрөм 5, цэвэрлэх байгууламж 1, үерийн хамгаалалтын далан 10, цооног 14 бүртгэгдсэн байна.

Бид одоо 4 суманд усны тоо бүртгэл жишиг байдлаар хийж судалгааны ажил явуулж байгаа ба булаг усны мониторингийн дэвтэр хэвлүүлж өгөхөөр бэлтгэл ажил хангаад байна. Уг мониторингийн дэвтэрт тухайн суманд байгаа булагийн сансрын болон фото зураг,



түүх хэмжилтийн судалгаанууд байх юм. Уг дэвтэрийг хэвлүүлсэнээр сумын байгаль орчны ажилтанууд жил бүр ажиллаад дүнг ирүүлэх ба жил бүр бид хөрөнгө мөнгө зарцуулж булаг тоолоод яваад байх шаардлаггүй болж байгаа юм.

Увс нуур болон Тэс, Боршоо, Баруунтуруун, Хангилцаг, Хариг, Хархираа, Түргэн голуудад усны харуул ажиллаж байна.

## ГАДАРГЫН УС

Тэс, Залаа, Ужиг, Асгат, Элээт, Жарантай, Буриа, Гөгсөг, Их ямаат, Шавар, Хос, Үнэгт, Цэрэг, Хачиг, Буга согоот, Баруунтуруун, Зүүнтуруун, Хангилцаг, Марц, Билүү, Нарийн, Гурмасан, Торхилог, Хандгайт, Боршоо, Сагил, Гашуун, Тээл, Хөндлөн зэрэг томоохон гол, мөнх цаст уулсаас эх авч урсдаг Хархираа, Түргэн, Хариг зэрэг нийт 256 гол, горхитой. Ихэнх голуудын эцсийн цутгал Увс нуурт цутгадаг. Увс нуурын 57% буюу хамгийн том цутгал нь Тэс гол юм.

Тус сав газрын ихэнх голууд өндөр уулнаас эх авч байгалийн хэд хэдэн бүс бүслүүр дамжин урсах ба гол төлөв эгц гадаргуугаас усжих учир урсгалын хурд их, жижиг ширхэгтэй зөөлөн хурдас урсгалаар угаагдаж голдуу суурь чулуу ил гарч, хайрга, бул чулуу ёроолын хурдсыг бүрдүүлдэг тул цэнгэг устай юм.

2012 оны хяналт- шинжилгээний дүнгээр бохирдлын индексийг бодож, усны чанарын зэргийг тогтоож 6 ангилалаар үнэлсэн үнэлгээгээр тус сав газарт хамаарах Тэс, Түргэн, Хархираа, Боршоо, Сагил, Торхилог голууд маш цэвэр ангилалд, Баруунтуруун, Хангилцаг, Гашуун, Билүү, Хандгайт, Гэдрэг голууд цэвэр ангилалд бүртгэгдсэн байна.

Зүүнговь сумын Урт булаг, Зүүнхангай сумын Хүнхийн рашааныг орон нутгийн зориулалтын рашаан сувилалаар ашиглаж байна. Мөн Увс аймгийн Түргэн сумын Буцалдаг, Бургастай, Малчин сумын Хүрэн морьт, Сэрүүн, Цагаанхайрхан сумын Ганц харгайт, Улаангом сумын Чандмана уул, Чулуут, Дэлгэрмөрөн, Хөвсгөл аймгийн Цэцэрлэг сумын Дошинт, Цахир түрүү, Завхан аймгийн Асгат сумын Сант, Баянхайрхан сумын Элст, Минжийн рашаан төст булгууд байна.

Хархираа, Түргэний уулс мөнх цас, мөсөн гол элбэгтэй бөгөөд Монгол орны уулсын мөсдлийн нийт талбайн 20 гаруй хувийг эзэлдэг байна.

## Сав газрын захиргаа

Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 254-р тогтоол, Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2013 оны Б-27 тоот тушаалаар Увс нуур-Тэс голын СГЗ-ны дарга томилогдож, “Увс нуур-Тэс голын сав газрын захиргааны дүрэм, бүтэц, зохион байгуулалтыг батлах тухай” Сайдын А-217 тоот тушаалаар тус сав газрын захиргаа байгуулагдсан. Дарга 1, мэргэжилтэн 5, үйлчилгээний ажилтан 1 нягтлан бодогч 1 нийт 7 орон тоотойгоор үйл ажиллагаагаа явуулж байна

Байгууллагын алсын хараа нь **“Ирээдүй хойчдоо хүрэлцээтэй, баталгаатай ус үлдээж, сав газрынхаа экосистемийг тэнцвэртэй хадгалах”**, эрхэм зорилго нь **“Сав газарт нийгэм, эдийн засгийн өсөлт хөгжлийг дэмжихэд усны нөөцийг нутгийн иргэдийн оролцоонд түшиглэн зүй зохистой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх асуудлыг нэгдмэл байдлаар оновчтой төлөвлөн хэрэгжүүлэх”** гэж тодорхойлсон.

### 2021 онд хийгдэх ажлууд

1. Байгууллагын цахим хурал хийх тоног төхөөрөмжийн шинэчлэл хийнэ.
2. Ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн бүс тогтоож Аймгийн ИТХ-аар дахин хэлэлцүүлж батлуулж дэглэм мөрдүүлэх ажлаа үргэлжлүүлнэ.
3. 3 булгийн эхийг байгальд халгүй эко аргаар хашиж хамгаална.
4. Шинээр хэрэгжүүлэх менежментийн төлөвлөгөө боловсруулж батлуулна.
5. Булаг усны тооллогын мониторингийн дэвтэр хэвлүүлнэ.
6. Сав газрын талуудын оролцооны зөвлөл шинэчлэн батлуулж, сумуудад сав газрын оролцооны салбар зөвлөл байгуулж үйл ажиллагаа идэвхжүүлнэ.
7. Тэсийн голын монголчууд сэдэвт фестивал зохион байгуулна.
8. Булаг ус гол нуур цөөрөм рашааны тухай домог түүх цуглуулах уралдаан зарлаж товхимол болгож хэвлүүлнэ.



Сав газрын зөвлөл

## 251 БУЛАГ ШАНД, 15 РАШААН СЭРГЭЖЭЭ

Усны тухай хуулийн 7 дугаар зүйлд Улсын усны мэдээллийн сан нь гадаргын болон газрын доорх ус, рашааны төлөв байдал, орон зайн үзүүлэлт, усны нөөцийн нийт болон ашиглах боломжит хэмжээ, чанар, өөрчлөлт, хяналт-шинжилгээний дүн мэдээ, ус ашиглалт, хаягдал ус зайлуулахтай холбогдсон мэдээ, экологи-эдийн засгийн үнэлгээ, ус хэрэглэгч, ашиглагчийн тухай мэдээлэл, хайгуул, судалгааны тайлан, усны барилга байгууламжийн байршил, хүчин чадал, техникийн үзүүлэлт зэрэг мэдээллээс бүрдэнэ гэж заасан байдаг.

Усны тоо бүртгэлийг аймаг, нийслэл, сум, дүүргийн хэмжээнд тухайн шатны Засаг дарга жил бүр зохион байгуулж улсын усны мэдээллийн санд оруулах, 21 сав газрын захиргаа нь усны тоо бүртгэлийг жил бүр сав газрын хэмжээнд нутгийн захиргааны байгууллагагай хамтран зохион байгуулж, усны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад тайлагнах үүрэгтэй. Усны мэдээллийн сангийн мэдээлэлд үндэслэн улсын усны төлөв байдлын тайланг жил бүр усны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага гаргаж, тайлагнадаг.



2020 онд хийсэн усны тоо бүртгэлийн дүнгээр Монгол оронд нийт 6316 гол мөрөн, 3939 нуур, тойром, 12152 булаг, шанд, 554 рашаан, 290 усан сан, хөв цөөрөм, 59915 худаг байна. 2019 онд хатаж, ширгэсэн байсан 84 гол, мөрөн, 106 нуур, тойром, 251 булаг, шанд, 15 рашаан 2020 онд сэргэсэн байна.

## УС БОХИРДУУЛСНЫ ТӨЛБӨРТ ХИЧНЭЭН ТӨГРӨГ НОГДУУЛАВ?

Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл УИХ-ын 2019 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн нэгдсэн чуулганы хуралдаанаар хэлэлцэгдэн батлагдсан. Хуулийн гол нэмэлт өөрчлөлтөөр ус бохирдуулсны төлбөрийн дээд болон доод хэмжээг өөрчилж, бохирдол ихсэх бүрт төлбөр нэмэгдэх зарчмыг баримтлан хаягдал усаа стандартад нийцүүлэн цэвэрлэж байгаа иргэн, аж ахуйн нэгж байгууллагын үйл ажиллагааг бодлогоор дэмжих асуудлыг хуулийн нэмэлт өөрчлөлтөөр тодорхой тусгаж өгсөн.

Хууль батлагдсантай холбогдуулан Монгол Улсын Засгийн газар, Байгаль орчин, аялал жуулчлалын яамны зүгээс тогтоол шийдвэрүүдийг албажуулан нийтээр дагаж мөрдөх захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгүүлээд байна.

Усны газрын хэрэгжүүлэх үндсэн үйл ажиллагааны нэг зорилтын хүрээнд “Ус

бохирдуулсны төлбөрийн тухай хууль”-ийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, хаягдал усыг цэвэрлэж дахин ашиглах, эргүүлэн ашиглах бодлогыг дэмжих, Үр ашигтай хэрэглээг төлөвшүүлэх, ус хэмнэх, хаягдал усыг цэвэрлэх, дахин ашиглах техникийн нөхцөл, стандартыг дэвшилтэт технологи, шинжлэх ухааны ололтод тулгуурлан боловсруулж, хэрэгжилтэд хяналт тавих үүрэг бүхий Усны хяналт шинжилгээний хэлтэс нь 7 хүний бүрэлдэхүүнтэйгээр ажиллаж байна.

Усны тухай хуулийн 24.2-д заасны дагуу хоногт 50 шоо метрээс их, аюултай бохирдуулах бодис агуулсан хаягдал ус гаргадаг ус бохирдуулагчид усны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага дүгнэлт гаргаж, тус дүгнэлтийг үндэслэн сав газрын захиргаа, хоногт 50 шоо метрээс бага хаягдал ус гаргадаг, аюултай бодис агуулаагүй ус бохирдуулагчид сав газрын захиргааны дүгнэлтийг үндэслэн сум, дүүргийн Засаг дарга хаягдал ус хаях, зайлуулах

зөвшөөрлийг олгоно гэж заасан.

Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуулийг хэрэгжүүлснээр хоногт 50 шоо метрээс бага хаягдал ус гаргадаг аж ахуйн нэгж, байгууллагад Усны тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэгт заасан дүгнэлтийг үндэслэн сум, дүүргийн Засаг дарга ус бохирдуулсны төлбөрийн гэрээ байгуулах, хаягдал ус хаях зайлуулах зөвшөөрөл олгох ба Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2, 4.3 дахь хэсэгт тус тус заасны дагуу ус бохирдуулагчийн талаарх мэдээллийг харьяалах татварын албанд хүргүүлэх үүрэгтэй.

Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуулийг хэрэгжүүлж эхэлснээр 2020 онд 24, 2021 онд 59 аж ахуйн нэгж байгууллагын дүгнэлтийг гаргаж нийт 12 гаруй тэрбум төгрөгийн төлбөрийг ногдуулсан байна.



## АЖИЛДАА ЭЗЭН, МЭРГЭЖИЛДЭЭ МЭРГЭН БАЙХЫН САЙХАН



*Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Усны газар энэ зун шагналын хур арвинтай байлаа. Усны газрын дарга Ш.Мягмар, ахлах мэргэжилтэн Д.Өнөржаргал, Увс нуур Тэс голын сав газрын дарга Анхбаяр нар “Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одон”-гоор шагнуулж, өндөр төрдөө “үнсүүллээ”. Усны салбарт 30 шахам жил үйлс бүтээлээ өссөн эрхмүүддээ “Цэнхэр алт” сонины редакци халуун баяр хүргэж, цаашидын ажил үйлст нь шинэ шинэ амжилтыг хүсэн ерөөе. Энэ дугаартаа бид Усны нөөцийн хэлтсийн ахлах мэргэжилтэн Д.Өнөржаргалын ажил үйлс, амжилт бүтээлийн тухай толилуулж байна.*

Түүний төрсөн өдөр хамгийн гоё баярын өдөр байдаг. Дамдинбазарын Өнөржаргал 1967 оны 03-р сарын 08-нд Улаанбаатар хотод сэхээтний гэр бүлд төрсөн. Төгөлдөр өдөр мэндэлсэн тэрбээр төрсөн өдрөө их ч гоё тэмдэглэдэг. Улс орон шинэ нийгэмд шилжиж байх үед тэрбээр их сургуулиа дүүргэж, ажил амьдралд хөл тавьжээ. Өнөржаргал 1991 онд ОХУ-ын Эрхүү хотын Политехникийн дээд сургуулийг гидрогеологич инженер мэргэжлээр төгссөн. 1993 оноос Байгаль орчны яамны харьяа Усны бодлогын хүрээлэнгийн газрын доорх усны секторт гидрогеологич инженерээр орж ажилласнаар улсад тасралтгүй 30 жил ажиллаж байна.

Тэрбээр 1993 оноос Байгаль орчны яамны харьяа Усны бодлогын хүрээлэнд, 1997 оноос ШУА-ийн Геоэкологийн хүрээлэнгийн усны нөөц, ус ашиглалтын салбарт эрдэм шинжилгээний ажилтан, 2010 оноос ЗГХА Усны Газарт мэргэжилтэн, хэлтсийн дарга, 2012 оноос БОНХЯ-ны Бодлого зохицуулалтын газрын усны нөөцийн хэлтэст ахлах мэргэжилтэнгээр, 2014 оны

12-р сараас БОНХАЖЯ-ны Газар зохион байгуулалт болон усны нэгдсэн бодлого зохицуулалтын газрын Усны нөөцийн хэлтэст ахлах мэргэжилтнээр, 2020 оны 8-р сараас ЗГ-ын хэрэгжүүлэгч агентлаг Усны газарт усны нөөцийн хэлтсийн ахлах мэргэжилтнээр ажиллаж байна. Техникийн ухааны магистрийн, Монгол Улсын Зөвлөх инженер зэрэгтэй.

БОЯ-ны Усны бодлогын хүрээлэнд 1993 оноос газрын доорхи усны нөөц тогтоох эрэл хайгуулын ажил, усны өрөмдлөгийн бригадыг ахлан ажиллаж нийт 10 аймгийн 12 сумын төвийн ус хангамжийн асуудлыг шийдвэрлэх усны нөөцийн эрэл хайгуулын ажилд биечлэн оролцож, түүнчлэн Улаанбаатар хот орчмын газрын доорх усны горимын судалгааны ажлыг явуулж, ус хангамжийн 7 эх үүсвэрт газрын доорхи усны түвшний өөрчлөлтийн хяналт хэмжилтийн цэгүүдийг байгуулан ажилласан.

1996-1998 онуудад Улаанбаатар хотын ус хангамжийн эх үүсвэрүүдэд газрын доорхи усны мониторингийн судалгааны ажил,

1999-2001 онуудад “Монгол орны усны нөөц, экологи-эдийн засгийн үнэлгээ, усны нөөцийг зөв зохистой ашиглах хамгаалах шинжлэх ухааны үндэслэл” төслийн газрын доорх усны экологи-эдийн засгийн үнэлгээний суурь 1:1 саятын хураангуйлалтай зургийн 3 листийн зохиогчоор ажилласан. Мөн энэ төслийн хүрээнд “Монгол орны газрын доорхи усны байгалийн горимын зүй тогтол”-ын зураг (1:2500000 хураангуйлалтайгаар) гаргасан. 2001-2004 онуудад “Монгол орны усны нөөц, экологийг хамгаалах шинжлэх ухааны суурь судалгаа” шинжлэх ухааны төслийн “Монгол орны газрын доорх усны горим бүрэлдэн тогтох зүй тогтол, экологийн өөрчлөлт”-ийн хэсэгт бие даан ажиллаж, “УБ хот орчмын газрын доорх усны экологийн нөхцөлийн тойм зураг” (1:25000 хураангуйлалтай); “Улаанбаатар хот орчмын гидрогеологийн зураг” (1:100000 хураангуйлалтай) 2 зураг, арга зүй, тайлбар бичгийн хамт тус тус гаргасан. Мөн байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний ажлуудад удаа дараа оролцож газрын доорх ус, усан хангамж, усны хэрэглээ, газрын доорх усны нөөцийн чиглэлээр 100 гаруй ажилд шинжээчээр оролцон ажиллажээ.

2005-2007 онуудад шинжлэх ухааны “Томоохон сав газруудын усны нөөцийн үнэлгээ, усан орчны экологийн судалгаа” суурь судалгааны ажлын “Эдийн засгийн бүсүүдийн газрын доорхи усны мэдээллийн санг газар зүйн мэдээллийн системтэй уялдуулан газрын доорхи усны санг шинэчлэн бүрдүүлэх ажил”, суурь судалгааны ажлын үр дүнд гарсан “Монгол орны газрын доорхи ус, түүний өөрчлөлт” номын 4-6-р бүлгүүдийг бичиж хамтарсан зохиогчоор ажилласан.

Дэлхийн цөмийн энергийн комиссоос 2005-2006 онуудад хэрэгжүүлсэн “Газрын доорх усны бохирдлыг изотопын

аргаар тодорхойлох” төслийн ажилд Улаанбаатар хотын газрын доорх усны эх үүсвэрүүд, говийн бүсийн газрын доорх усны зүй тогтолыг тогтоох, усны насжилтыг тодорхойлох чиглэлээр гидрогеологич - инженерээр ажиллаж, ус хангамжийн Төв, Дээд, Үйлдвэрийн эх үүсвэрүүдийн газрын доорх усны насжилтыг тогтоох ажлыг шинэ арга аргачлалаар хийж, үр дүнгийн тайлангуудыг Дэлхийн цөмийн энергийн комисс, ШУА-ийн Их чуулганаар хэлэлцүүлсэн.

ШУА-ийн Геоэкологийн хүрээлэнгийн усны нөөц, ус ашиглалтын салбарт 2008 оноос хэрэгжсэн шинжлэх ухааны “Туул голын ай савын усны нөөцийн менежментийн загварчлал, усан орчны экологийн судалгаа” сэдэвт суурь судалгааны ажлын Туул голын ай савын газрын доорхи усны нөөц, экологийн өөрчлөлтийн чиглэлээр ажиллаж, “Туул голын ай савын усны нөөцийн менежментийн загварчлал, усан орчны экологийн судалгаа” эрдэм шинжилгээний хамтарсан бүтээлийг гаргаж, хэвлүүлсэн. 2006-.2007 онуудад МУИС-ийн Газар зүй-геологийн сургуульд “Гидрогеологи”-ийн 2 кредит, “Геоэкологи”-ийн 2 кредит цагийн лекцийг 3 жил дараалан багшилж, нийт төгсөх 10 оюутны дипломын ажлыг удирдан төгсгөн залуу үеийг сурган мэргэжилтэн боловсон хүчин бэлтгэхэд хувь нэмэр оруулсан.

Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Усны газарт 2010 оноос Усны нөөцийн хэлтсийн мэргэжилтэн, усны нөөцийн хэлтсийн даргаар, 2012 оноос БОНХАЖЯ-ны усны нөөцийн хэлтэст ахлах мэргэжилтнээр, ЗГ-ын хэрэгжүүлэгч агентлаг Усны газарт ахлах мэргэжилтнээр тус тус тасралтгүй ажиллаж, ажиллах хугацаандаа Монгол орны усны нөөцийг тогтоох, ашиглах хамгаалах бодлогын хүрээнд ус хангамжийн эх үүсвэрийн газрын доорх усны эрэл хайгуулын ажлыг зохион байгуулж, усны нөөцийг баталгаажуулах ажлуудыг хийж, уул уурхайн томоохон төслүүдийн усны нөөцийн эх үүсвэрүүдийг тогтоох, усны

ашиглалт, хамгаалалт, усны нөөцийн асуудлуудыг шийдвэрлэхэд гар бие оролцож ажилласан.

Усны салбарт ажиллах хугацаандаа бодлогын баримт бичиг, хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах, салбарт тулгамдаж байгаа асуудлуудыг гаргаж, хүн амын унд ахуйн ус хангамжийн эх үүсвэрийн нөөц, ус ашиглалт, хамгаалалтын ажлуудыг жил бүрийн төсөвт оруулах зэрэг ажлуудыг зохион байгуулж ажиллахад хувь нэмрээ оруулж ирсэн.

Газрын доорх усны нөөцийг ашиглах, хамгаалах, усны ашиглалтыг хянах зорилгоор Монгол улсын хэмжээнд газрын доорх усны хяналт шинжилгээний сүлжээг анх байгуулж, мэргэжил арга зүйгээр ханган төсөл хөтөлбөр, улсын хөрөнгө оруулалтаар шийдвэрлэж, одоогийн байдлаар Монгол орны нийт нутаг дэвсгэрийн говийн бүс нутагт 45%, Улаанбаатар хотод 28%, бусад тал хээрийн бүсэд 27%-ийг хамруулан газрын доорх усны хяналт шинжилгээний 280 цэгийг байгуулан, газрын доорх усны хяналт шинжилгээний нэгдсэн сүлжээнд бүрэн автомат 40, хагас автомат 240 багаж тоног төхөөрөмж суурилуулан холбож, мэдээллийн нэгдсэн сайт ажиллаж байна.

Мөн 2019 оны байдлаар Монгол улсын тогтвортой хөгжлийн зорилт, Засгийн газрын үйл ажиллагааны нэг болох Дорноговь аймгийн Алтанширээ сумын нутагт байгуулсан Нефть боловсруулах үйлдвэрийн ус хангамжийн эх

үүсвэрийг Бор хөөврийн газрын доорх усны ордоос хангах ажлыг зохион байгуулж, мэргэжил арга зүйгээр ханган ажилласан.

Усны эх үүсвэрийг тогтоох улсын хөрөнгө оруулалтын болон аж ахуйн нэгж байгууллагуудын өөрийн хөрөнгөөр хийсэн газрын доорх усны нөөц тогтоох хайгуул судалгааны ажлын үр дүнгээр тогтоосон 100 гаруй усны нөөцийн тайланг усны нөөцийн зөвлөлд оруулан хэлэлцүүлэхэд гар бие оролцож, усны нөөцийн мэдээллийн санд холбогдох баяжуулалтыг хийж, нийт газрын доорх усны 385 ордын мэдээллүүлийг нэгтгэн ажиллаж байна.

Д.Өнөржаргал нь ажиллах хугацаандаа ШУА-ын “Хүндэт жуух бичиг”, БОЯ-ны “Хүндэт жуух бичиг”, БОНХЯ-ны “Монгол улсын байгаль орчны тэргүүний ажилтан” цол тэмдэг, БХБЯ-ны “Нийтийн аж ахуйн тэргүүний ажилтан” цол тэмдэг, 2017 онд Төрийн дээд шагнал “Алтан гадас” одонгоор тус тус шагнагдсан.

Төрийн албанд 30 гаруй жил тасралтгүй тогтвор суурьшилтай, ялангуяа байгаль орчны бодлого, түүний дотор усны салбарт оруулсан хувь нэмрийг өндрөөр үнэлж, түүнийг саяхан төрийн дээд шагнал “Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одон”-гоор шагнасан юм. Ажилдаа эзэн, мэргэжилдээ мэргэн байхын сайхан ийм байдаг ажээ.



## Я.БОЛДБААТАР: ХУЛЖИЙН РАШААНЫ НӨӨЦИЙГ ТОГТООХ АЖИЛ ИД ХИЙГДЭЖ БАЙНА



*Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Усны газар дөрвөн хэлтэстэй. Усны нөөцийн хэлтсийн дарга Я.Болдбаатартай уулзаж дараах зүйлийг тодруулан ярилцлаа.*

**-Усны нөөцийн зөвлөл саяхан хуралдсан байна. Энэ зөвлөл ямар хүмүүсээс бүрддэг, ямар шийдвэр гаргадаг тухай мэдээлэл өгнө үү?**

“Усны нөөцийн зөвлөл” нь Байгаль орчны сайдын тушаалаар батлагддаг. Арвандолоон хүний бүрэлдэхүүнтэй, усны салбарын нэр хүндтэй эрдэмтэд, төрийн болон төрийн бус байгууллагын төлөөллөөс бүрддэг. Энэ зөвлөлийг Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Төрийн нарийн бичгийн дарга тэргүүлдэг. Зөвлөл маань улирал тутамд хуралдаж ирсэн тайлангуудыг хэлэлцэж шийдвэрлэдэг. Зөвлөлийн хурлын шийдвэр нь Дүгнэлт, Зөвлөмж маягаар гардаг бөгөөд хурлын тэмдэглэлд тусгадаг. Өнгөрсөн жилд Усны нөөцийн зөвлөл долоон тайлан хэлэлцсэн.

**- Саяын хурлаар олон тайлан хэлэлцэв үү?**

-Усны нөөцийн зөвлөл тавдугаар сарын дундуур хуралдахдаа зургаан тайлан хэлэлцсэн бөгөөд тэдгээрийн дөрөв нь нөөц батлуулах тайлан байлаа. Бас Азийн хөгжлийн банкны төсөл санхүүжилтээр хийгдэж буй “Усны засаглалыг шинэлэг арга замаар хэрэгжүүлэх нь” төслийн хүрээнд газрын доорх усыг зориудаар арвижуулах гурван загвар төслийн танилцуулга байлаа. Нөгөө

нэг нь “Төвийн бүсийн үйлдвэр, уул уурхайн ус хангамжийг нэмэгдүүлэх төсөл”-ийн ТЭЗҮ тайланг хэлэлцсэн юм.

**- Томоохон төслийн ТЭЗҮ энэ зөвлөлөөр эхэлж орж танилцуулагддаг юм байна. Өнгөрсөн жил “Орхон-Онги голын ТЭЗҮ-г баталлаа гэж дуулдаж байсан. Томоохон хот суурин газрын Усны нөөцийг тогтоох ажлыг танай хэлтэс гардан хийж байна уу?**

-Тийм ээ. Манай хэлтэс дээр голлон төвлөрч хийгдэнэ. Сумын төвийн

хүн амын унд, ахуйн усны нөөцийг тогтоох ажил үе шаттай хийгдэж байна. Яг одоо Өвөрхангай аймгийн Хайрхандулаан сумын төвийн хайгуул судалгааны ажил хийгдэж байна. Энэ жил нийслэл хотын томоохон нэг хэсэг болсон Багануур дүүргийн усан хангамжийн нөөцийг тогтоох ажил хийж байна.

**-Шинээр бий болох Майдар хотын усны нөөцийг тогтоох ажил бас хийгдэж байгаа юу?**

-Энэ ажил хийгдээд дууссан. Харин саяхан манайхаас нэмэлт хайгуулын талбай зааж өгсөн. Тийм болохоор тэр талбайд бас нөөц тогтоох ажил эхэлж байгаа.

**- Рашаан уснуудын нөөцийг шинэчлэн тогтоох ажил ямар шатандаа яваа вэ? Социализмын үед нөөцийг нь тогтоож баталснаас хойш төдий л хайхарч судалгүй нэг хэсэг орхигдсон байх аа?**

-Хоёр жилийн өмнөөс томоохон рашаан, шавар усны нөөцийг шинэчлэн тогтоох ажил хийгдээд явж байгаа. Өвөрхангай аймгийн Хужиртын рашааны нөөцийг шинэчлэн тогтоогоод байгаа. Мөн өнгөрсөн жил Шаргалжуутын нөөцийг тогтоох, судлах ажил хийгдлээ. Энэ жил Булган аймгийн Могод сумын нутагт байдаг Хулжийн рашааны нөөцийг тогтоох ажил ид хийгдэж байна.





ажилтнуудаа ерөнхийд нь удирдан чиглүүлнэ, устай холбоотой мэдээллийг багцалж, нэгтгэн зангидаж байдаг.

**-Хөвсгөл нуурыг бохирдлоос гаргах, нууранд живсэн автомашинуудыг татан гаргах Засгийн газрын тогтоол гарсан байдаг. Энэ ажилд Усны газар хэрхэн оролцож байна вэ?**

-Энэ тогтоолыг хэрэгжүүлэх хэд хэдэн ажлын хэсэг байгуулагдсан юм. Дэд хэсэгт манай Усны газрын ажилтнууд орсон. Нуурын гүнд байгаа автомашин, эд зүйлсийг татан гаргадаг ОХУ-ын мэргэшсэн “Форт-21” гэдэг компани байдаг юм. Бид тэдэнтэй холбогдож хоёр ч удаа онлайн хурал зохион байгуулаад байна.

**-Аймаг орон нутагт ажиллаж байгаа сав газрууд усны тооллого бүртгэлийг жил бүр хийдэг. Энэ мэдээллүүдийг бас танай хэлтэс нэгтгэж байна уу?**

-Тийм ээ, манай хэлтэс нэгтгэдэг. Бас Газрын доорх усны эрэл хайгуулын судалгааны ажлын даалгаврыг манайх баталдаг. Уул уурхай, аялал жуулчлал гэх мэт устай холбоотой бүхий ажил үйлчилгээ явуулахад байгаль орчны үнэлгээ хийлгэдэг журамтай. Үүнийг батлуулахын тулд “Ус ашиглах боломжит нөөц”-ийн дүгнэлт гаргах учиртай. Энэ ажлыг бас манай хэлтэс хариуцдаг. Одоогоор 100 гаруй дүгнэлт гаргаад байна. Энэхүү дүгнэлтээрээ усны нөөцөө байнга хянаж байдаг.

**-Уул уурхайн үйлдвэрлэл явагдаж байгаа говь нутгийн усны нөөцийг тогтоох тал дээр ямар даацтай ажлууд хийгддэг юм бол? Таван толгой, Оюу толгойн нөөцийг боломжийн гэж үздэг үү?**

-Таван толгойн Дулааны цахилгаан станцад ашиглах усны нөөцийг шинэчлэн тогтоох ажил яригдаж, ажил эхлээд явж байгаа. Тавантолгойд үйл ажиллагаа явуулж байгаа гол үйлдвэрлэгч “Энержи ресурс”компанитай хэд хэдэн уулзалт зохион байгуулсан. Үүний үр дүнд хоёр компани гэрээгээ хийгээд ажлаа эхэлж байгаа. Мөн Дорноговь аймгийн Мандах сумын нутаг дах Цагаанцавын ордыг эзэмшигч “МАК”компанитай ярьж тохироцож байна. Өмнөх нийгмийн үед улсын төсвийн хөрөнгөөр судалгаа шинжилгээ нь хийгдсэн орд газрыг эзэмшиж байгаа бол нөхөн төлбөр олгох учиртай. Тэрхүү нөхөн төлбөр олгуулах ажил хийгдээд явж байна.

**-Газрын доорх усаа хянаж байх зориулалт бүхий мониторингийн олон арван цооног гаргасан. Тэрхүү цооноогоо нэмэгдүүлж байна уу?**

-Тийм ээ, хагас болон бүрэн автомат холболттой мониторингийн 290 гаруй цооног бий. Тэрхүү цооногуудаар газрын доорх усаа хянаж байна. Ийм цооногийг жил бүр шинээр суурилуулж нэмэгдүүлэх бодлого баримталж байгаа. Энэ жил гэхэд л таван цооног шинээр суурилуулж байна.

**-Танай хэлтсийн мэргэжилтнүүд ямар ямар асуудал эрхлэн хариуцдаг вэ? Ажилдаа эзэн болсон гар, сэтгэл нийлсэн хамт олон ямар ч ажлын ард төвөггүй гардаг даа?**

-Усны 21 сав газраа хариуцсан болон гадаргын усны мэргэжилтэн байна. Газрын доорх усны эрэл хайгуулын мэргэжилтэн, усны үнэ тариф, үнэлгээ хариуцсан мэргэжилтэн байна. Ахлах мэргэжилтэн маань

## САЛХИТЫН МӨНГӨНИЙ ОРДОД АЖИЛАЛАА

Дундговь аймгийн Гурвансайхан сумын нутаг дахь Салхитын мөнгөний ордын уулын баяжуулах үйлдвэрийн технологийн усан хангамжийн газрын доорх усны нөөц өсгөх эрэл хайгуулын ажлын гүйцэтгэлд Усны газрын мэргэжилтнүүд хяналт тавьж, мэргэжлийн арга зүйгээр хангалаа. Дээрх эрэл хайгуулын ажлыг “Эрдэнэс Силвер Ресурс” ХХК-ийн захиалгаар “Ташрын хүрээ” компани хийж гүйцэтгэсэн байна. БОАЖЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын баталсан ажлын даалгаврын дагуу дээрх ажлыг хийжээ. Усны газрын мэргэжилтнүүд Газрын доорх усны эрэл хайгуулын ажлын болон Гидрогеологийн эрэл хайгуулын ажлын үр дүнтэй танилцан дүгнэлтээ гаргалаа. Улмаар баталсан аргачлалын дагуу

гидрогеологийн эрэл-хайгуулын судалгааны ажлын тайланг бэлтгэж, усны нөөцийн зөвлөлөөр хэлэлцүүлэх дүгнэлт гаргав.



## УМАРД ГОВИЙН ГҮВЭЭТ-ХАЛХЫН ДУНДАД ТАЛЫН САВ ГАЗРЫН ЗАХИРГАА

Умард говийн гүвээт-Халхын дундад талын сав газрын захиргаа нь “Усны тухай” хууль болон холбогдох хууль, тогтоомжийн дагуу үйл ажиллагаа явуулдаг төрийн захиргааны байгууллага юм.

Сав газрын захиргаа нь “Говийн бүсийн экосистемийн тэнцвэрт байдлыг хадгалах боломжит усны нөөцийг бий болгох, хүн ам, хөдөө аж ахуй, үйлдвэрлэлийг нийгэм, эдийн засгийн хөгжлийн зорилгоо биелүүлэх бүхий л хэрэгцээнд нь нийцсэн баталгаат усаар хангах, усны нөөцийг зүй зохистой ашиглах” алсын хараатай ажиллаж байна.

Манай сав газрын захиргаа нь 8 аймаг 58 сум, 1 дүүргийн хэмжээнд сав газрын менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх орон нутгийн болон салбар дундын зохицуулалтыг хангах, сав газрын хэмжээнд ашиглах боломжит усны нөөц, ус ашиглалтын байдалд байнгын хяналт тавьж ажиллах, Усны тухай хууль болон Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуулийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд ус ашиглах иргэн, аж ахуй нэгж, байгууллагын хүсэлтийг хүлээн авч, ус болон усан орчин ашиглуулах дүгнэлт гаргах, ус ашиглах зөвшөөрөл олгож, гэрээ байгуулах, ус бохирдуулагч ААНБ-д хаягдал ус хаях, зайлуулах дүгнэлт гаргах, хаягдал ус хаях, зайлуулах зөвшөөрөл олгох, гэрээ байгуулах, усны тоо бүртгэлийг жил бүр сав газрын хэмжээнд нутгийн захиргааны байгууллагатай хамтран зохион байгуулдаг.

Умард говийн гүвээт-Халхын дундад талын сав газар нь Монгол орны газар нутгийн 11,3 хувийг ба 178182,2 км<sup>2</sup> газар нутгийг эзэлдэг бөгөөд тал хээр, говийн бүсэд багтдаг.

Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2018 оны 05 сарын 30-ны өдрийн А/158 дугаар тушаалын 14-р хавсралтаар 10 орон тоотойгоор бүтэц орон тоо багтагдсан.


### 2021 оны эхний хагас жилийн байдлаар хэрэгжүүлсэн ажлын товч мэдээлэл

Усны тухай хуулийн хүрээнд

- 14 ус ашиглагч ААНБ-д ус ашиглуулах дүгнэлтийг гарган 142'546.5 шоометр усны 91'326'729.0 төгрөгийг төсөвт төвлөрүүлэх боломж бүрдүүлэн ажилласан.
- “Усны газар”-аас гаргасан ус ашиглуулах дүгнэлтийн дагуу 16 ААНБ-д 6'094'094.2 шоометр ус ашиглуулж 2'231'842'316.3 төгрөг улсын төсөвт төвлөрүүлэх гэрээ байгуулж ус ашиглах зөвшөөрлийг олгон ажилласан.
- Ус ашиглалт, хэрэглээг тоолууржуулах журмын хэрэгжилтийн хүрээнд эхний хагас жилийн байдлаар 8 аж ахуй нэгж байгууллагын 30 ширхэг тоолуур шинээр суурилуулж 8.138.0 сая төгрөг зарцуулагдсан байна. Сав газрын хэмжээнд нийт 165 ширхэг тоолуур суурилагдсан байна.

- Дундговь аймгийн 15 сумын хэмжээнд 2020 оны уст цэгийн тоо бүртгэлийн дүн мэдээнд боловсруулалт хийж МС1:100'000 байр зүйн зураг, сансрын хиймэл дагуулын мэдээнүүдэд харьцуулалт хийн усны сан бүхий газрын энгийн болон онцгой хамгаалалтын бүсийг зурагжуулсан. Дээрх ажлыг аймгийн ИТХ-аар батлуулахаар ажиллаж байна.
- Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуулийн хүрээнд:
- 213 аж ахуй нэгж байгууллагад 65996м<sup>3</sup>/жил хаягдал ус хаях, зайлуулах дүгнэлтийг гаргасан. Үүнд: Говьсүмбэр аймагт 43, Дундговь аймагт 100, Сүхбаатар аймагт 47, Багахангай дүүрэг 1, Хэнтий аймагт 5, Дорноговь аймагт 17 аж ахуй нэгж байгууллагууд.
- Ус бохирдуулсны төлбөрийн тухай хууль болон дагалдан гарсан захиргааны хэм хэмжээний актын талаар сумдын Засаг дарга нар, байгаль орчны хяналтын улсын байцаагч, байгаль хамгаалагч нарт 1 удаагийн сургалт, аж ахуй нэгж байгууллагад 3 удаагийн сургалт, Сав газрын талуудын оролцооны зөвлөлд 2 буюу нийт 6 удаа цахим сургалтыг зохион байгуулж 83 албан хаагч, аж ахуй нэгж байгууллагын төлөөллийг хамруулсан.
- “Усны газар”-аас гаргасан хаягдал ус хаях зайлуулах дүгнэлтийг үндэслэн 6 ААНБ-д 15'256'019.51 төгрөгийн ус бохирдуулсны төлбөрийн гэрээ байгуулсан.

Засгийн газрын 2014 оны 43-р тогтоолын хүрээнд аймгийн Засаг дарга болон БОАЖГ-уудад ус, усан орчинг хамгаалах, нөхөн сэргээх ажлуудыг хэрэгжүүлэхэд шаардлагатай төсвийн санал хүргүүлэн ажилласны үр дүнд БХНСАХЗ болон аймаг орон нутгийн төсвөөс нийт 10 ажилд 1'002.5 тэр.бум төгрөг зарцуулагдахаар төлөвлөгдсөний дагуу үе шатны ажлууд хийгдэж хяналт тавин хамтран ажиллаж байна.



# ХЭРЛЭН ГОЛЫН САВ ГАЗРЫН ЗАХИРГАА



гүйцэтгэгч, Гадаргын усны нөөц, судалгаа шинжилгээний асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн Т.Баатарсүх,

- Усны нөөцийн нэгдсэн менежмент, төлөвлөлт, олон нийт, сургалт сурталчилгаа хариуцсан мэргэжилтнээр Э.Оюумаа,
- газрын доорх усны нөөц, ашиглалт хяналт шинжилгээ хариуцсан мэргэжилтнээр Г.Мөнхцог, (Багануурт байрлаж Төв аймаг, Багануур дүүргийн ус ашиглалтыг хариуцан ажилладаг),
- Газар зүйн мэдээлэл, усны мэдээллийн дэд сан хариуцсан мэргэжилтнээр Ч.Сайнбаяр,
- Усны барилга байгууламж, үйлдвэр, хөдөө аж ахуйн ус ашиглалт хариуцсан мэргэжилтнээр Б.Батдорж (Дорнод аймагт байрлаж Дорнод аймгийн ус ашиглалтыг хариуцан ажилладаг),
- Усны чанар, экологи, төлбөрийн асуудал хариуцсан мэргэжилтнээр Н.Намуунтуяа,



Нягтлан бодогчоор Б.Баяржавхлан, Нярав жолооч Д.Баярхүү нар ажиллаж байна.

Хэрлэн гол бол Монгол улсын хамгийн урт гол, Хэнтийн нуруунаас эх авч Монгол орны зүүн бүс нутгийн дундуур Дорнод Монголын Уудам их талын хойд хэсгээр 1382 км урсан Далай нуурт цутгадаг төдийгүй Амар мөрний нэг эх болж ОХУ, БНХАУ-ын нутгаар дамжин Агнуурын тэнгисээр Японы арлуудын хойд эрэгт Номхон далайд цутгадаг. Монгол орны нутагт 1163 км урсдаг.

Хэрлэн голын сав газрын нийт ус хурах талбай 107040 км<sup>2</sup> ба засаг захиргааны нэгжийн хамралтыг авч үзвэл 6 аймгийн 42 сум, нийслэлийн 2 дүүргийн газар нутаг бүхлээр ба хэсэгчилсэн байдлаар хамрагдах ба Монгол улсын нийт газар нутгийн 6.8 хувийг эзэлдэг.

Хэрлэн голын Сав Газрын захиргаа нь Монгол улсын Засгийн газрын “Сав Газрын захиргааны талаар авах арга хэмжээний тухай” 2012 оны 254 дүгээр тогтоол, Байгаль орчин, ногоон хөгжийн сайдын “Хэрлэн голын сав газрын захиргааны бүтэц, орон тоо, дүрэм батлах тухай” 2013 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн А/278 дугаар тушаалаар Багануур дүүрэгт дарга, мэргэжилтэн 6, нярав-жолооч, гэрээт нягтлан гэсэн бүтэцтэйгээр байгуулагдаж Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайдын 2015 оны А-106 дугаар тушаалаар 2015 оны 03 дугаар сараас Хэнтий аймгийн Чингис хотод үйл ажиллагаа явуулж байна.

- Даргын үүргийг түр орлон



## ҮЙЛ ЯВДЛЫН ЭРГЭН ТОЙРОНД

### “Цэвэр орчин, Цэнгэг ус” уриалгат ажил зохион байгуулав.

Хэрлэн голын сав газрын захиргаа, Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Онон, Улз голын сав газрын захиргаа, Хэнтий аймгийн Залуучуудын холбоо, Ус, цаг уур орчны шинжилгээний газар хамтран Дэлхийн байгаль хамгаалах сангийн санхүүжилтээр Хэнтий аймгийн хэмжээнд “Цэвэр орчин, Цэнгэг ус” уриалгыг дэвшүүлж зохион байгуулах ажлын удирдамжийг боловсруулан 2021 оны 6 дугаар сарын 17-ноос 7 дугаар сар 6-ныг хүртэлх хугацаанд зохион байгуулж



цахимаар оролцсон иргэдийн тоо 13547, “Үер усны аюулаас болгоомжлох, Голын хамгаалалтын бүсийн горимд хориглох үйл ажиллагаа, торгууль шийтгэл, Цэвэр Орчин-Цэнгэг ус уриалгад нэгдэн хог хаягдлыг хогийн саванд хийх, даавуун ууцыг хэрэглэж хэвших, ил гал түлэхэд хөрсийг гэмтээж ургамлын ургах орчинг сүйрүүлж байдаг” талаар нэгдсэн гарын авлага 500-г тараасан, машины наалт стикер 200-г тараасан.

Бургасан ойг нөхөн сэргээх, бургасыг хайрлан хамгаалахад иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, хууль эрх зүйн орчинг олон

нийтэд түгээх зорилгоор “Бургас тарьцаага, бургасаа хамгаалъя” богино хэмжээний видео нэвтрүүлэг уриалга бэлтгэн телевизээр цацуулж, цахим сүлжээнд байршуулж иргэдэд түгээсэн.

Хэрлэн голын онцгой хамгаалалтын бүсийн тэмдэгжүүлэлтийн самбарыг шинэчлэн хэвлүүлж, Цэвэр Орчин-Цэнгэг Ус уриалгыг олон нийтэд түгээж усаа хайрлан хамгаалж хэмнэх уриалга бүхий том-5, жижиг-5 нийт 10 самбарыг бэлтгэн хэвлүүлж 7 сарын 4-6-ны өдрүүдэд Хэнтий аймгийн Хэрлэн сумын нутгаар урсах Хэрлэн голын эрэг орчимд байршуулав.

### Ус бохирдуулсан төлбөрийн тухай хуулийн хэрэгжилт хангах ажлын хүрээнд

Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуулийн хэрэгжилтийг эрчимжүүлэх, тус хуулийн талаарх орон нутгийн удирдлага, ус ашиглагч аж ахуйн нэгжүүдийн мэдлэг, мэдээллийг сайжруулах, хаягдал усны дүгнэлт гаргах, гэрээ байгуулах, хаягдал ус хаях зайлуулах зөвшөөрөл олгохтой холбогдсон харилцаанд нэгдсэн ойлголт өгөх зорилгоор Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Усны газар, Хэнтий аймгийн Засаг даргын Тамгын газар, Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Татварын хэлтэс, Хэрлэн голын сав газрын захиргаа, Онон Улз голын сав газрын захиргаа, Умард говийн гүвээт - Халхын дундад талын сав газрын захиргаагай хамтран Сумдын Тамгын газрын дарга, Татварын улсын байцаагч, Байгаль орчны хяналтын улсын байцаагч, Байгаль хамгаалагч, уул уурхай, худалдаа үйлчилгээ, ахуйн үйлчилгээ, хүнс, хөнгөн үйлдвэрлэл, барилгын салбарын төлөөллийг орцуулсан сургалтыг Хэнтий аймгийн Засаг даргын орлогч Ц.Чогсомжавын баталсан 2021 оны 06 дугаар сарын 18-ны өдрийн удирдамжийн дагуу

тус сургалтыг 2021 оны 06 дугаар сарын 23, 24-ний өдөр Хэнтий аймгийн 18 сум 4 тосгоны төрийн байгууллагын төлөөлөл /ЗДТГ-ын дарга, Засаг даргын орлогч, БОХУБ, Татварын улсын байцаагч, Байгаль хамгаалагч/, ус бохирдуулагч иргэн, аж ахуйн нэгж байгууллагын төлөөллийг хамруулан 3 бүс болгон зохион байгуулав. Гурван удаагийн сургалтаар нийт 110 гаруй хүн хамрагдсан байна.

### Улсын болон орон нутгийн хамгаалалтад урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрыг авах

Хэнтийн нурууны томоохон голуудын урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газар, усны нөөцийг хомстолт, бохирдолтоос хамгаалах, экосистемийн тэнцвэрт байдлыг хангах, ойн сан, ургамлын нөмрөг, цэвдэгийг хамгаалах үүднээс онцгой ач холбогдол бүхий Хэрлэн голын урсац бүрдэх хэсгийн уулс болон ойн сан бүхий газрыг улсын болон орон нутгийн тусгай хамгаалалтад авах, газар нутгийн сүлжээг өргөтгөх нэн шаардлагатай байна.

Хэнтий аймгийн Өмнөдэлгэр сумын нутаг дэвсгэрт хамаарагдах Хэрлэн голын урсац бүрэлдэх томоохон цутгал гол болох Тэнүүн голыг орон нутгийн хамгаалалтад авах 72744.5 га талбай бүхий зураглал, саналыг боловсруулан Хан Хэнтийн УТХН-ын хамгаалалтын захиргаа, Бурхан халдун уул, түүнийг хүрээлсэн тахилгат газар нутгийн хамгаалалтын захиргаа, ТНС байгаль орчны олон улсын байгуулагуудтай хамтарсан ZOOM цахим хурлыг 3 удаа зохион байгуулаад байна. Гуравдугаар улиралд холбогдох аймаг сумдын удирдлага, албан тушаалтнуудад танилцуулах санал авахаар төлөвлөөд байгаа бөгөөд IV улиралд аймаг сумдын ИТХ-д танилцуулахаар төлөвлөн ажиллаж байна.

*Хэрлэн голын СГЗ-ны  
мэргэжилтэн Э.Оюумаа*

## РАШААН УСЫГ ХЭЗЭЭ ЯАЖ ХЭРЭГЛЭХ ВЭ?

Яруу найрагч Д.Равжаа “Цангасан хүнд мянган лан алтнаас нэгэн ооч ус тус болно” гэж усны ач холбогдлын тухай онож хэлжээ. Тэрбээр бас “Чийг арвидвал ус болно. Манан арвидвал үүл болно” хэмээн байгаль дахь усны эргэлтийн талаар товч тодруун дүгнэлт хийсэн байдаг.

- Эрдэсжилт болон химийн бүрэлдэхүүний бүрэлдэхүүний онцлог чанараараа цэнгэг уснаасаа ялгагдах, анагаах чанар бүхий хүйтэн, халуун булгийн рашаан хэмээнэ. Монголчууд рашааныг эмчилгээнд хэрэглэх болсоор их уджээ. Түүхчдийн тодорхойлж байгаагаар МЭ ҮШ-ҮШ зууны үед хиргис нар рашаан ашиглаж байж. XII зуун гэхэд рашаан усыг бүр ч тодорхой зорилгоор хэрэглэх болсон байв. Зажидын “Малай гандил”, “Ариун тунгалаг усан эрдэнийн ариутгал”, Өндөр гэгээн Занабазарын “Халуун рашаанд орох журам” зэрэг ном сударт рашаан усанд тодорхойлолт өгч, түүнийг ангилан үзсэн, чанар найрлагыг нь тодохойлохыг хичээсэн хийгээд монголчуудын рашаанд ордог өвөрмөц журам, уламжлалын талаар өгүүлсэн зүйл нэлээд байдаг. Зажидын “Малай ганил” судрыг сөхөхүйд: Замбутивийн рашааны усны чадлыг бүлээн, шимийн гэж ялгахын зэрэгцээ хий, шар, бадгана, цөс, шар усны өвчинд хэрэглэх амтлаг, эсгэлэн, гашуун, халуун, эхүүн гэсэн 5 зүйлийн рашаан байдаг хэмээгээд дор бүрийн ундарч гарсан газрын байдал, өнгө, үнэр, амт зэрэг шинжээр нь онцлон авч үзжээ.



Мөн дээр өгүүлсэн 5 зүйлийн рашаан тус бүрийг дээд, дунд, адгийн гэх мэтээр нарийвчлан ангилж, юу юунд хэрхэн хэрэглэхийг айлджээ. Эл сударт рашаан усыг “намрын цагт хий өвчинд, зуны улиралд гарын өвчинд, бадгана өвчинд хавар хэрэглэх сайн. Үдэш, үүрээр хий авчинд үдээс ураг юм уу үдийн дараахан бадгана өвчинд, өдөр дунд, шөнө дундын үед цусны ба шар өвчинд хэрэглэнэ.

- Бадгана өвчинд хоол идсэний дараа, цус, шарын өвчинд хоол шингэх үед, хий өвчинд хоол шингэсний дараа хэрэглэмүй. Ходоодны галын илч барагдсан, хоол үл шингэх зэрэгт бүлээсгэж, халуун өвчинд хүйтнээр хэрэглэнэ. Тэгээд дассан, дадсан сайн хоол унд, амттан шимтгэнээр биеэ сайн торд...рашааныг дур мэдэн хэрэглэвээс мунхаг үйл болно. ... Жирэмсэн хүнд бөөлжүүлэх, туулгах, нялх хүүхдэд чацын рашааныг тэвч гэх мэтээр олон зүйлийг өгүүлсэн байна.
- Рашаанд орох журмын талаар өөр сударт тодосгон заахдаа: “Арвай” хэлбэртэй орохыг эрхэмлэ хэмээжээ. Энэ нь рашаанд орох, уухдаа хугацааны дунд хүртэл багаас их болгон

ууж, орж, дахин аажим багасган, эхэлж ууж, орсон хэмжээгээр дуусга гэсэн үг болой.

- Бас хавар, намар, халуун рашаанд сайн дулаалж ор, даарч болохгүй. Рашааны халууныг багаас их болгон аажим нэм.7-14 хоног сондгой, тоо хэмжээгээр ууж, 7-21 хоног орж, гам сайн хийх, хүйтэн ус гатлах, бороо чийгэнд цохиулахыг болгоомжил. Олон рашаан хольж уух, өдөрт хэмжээгүй уух, орох нь өвчин болно гэж айлдсан байдаг.
- Монгол орон Хужирт, Жанчивлан, Шаргалжуут зэрэг алдартай 100 гаруй халуун, хүйтэн рашаантай. Тэдгээрийн дотор ганц хадны хоёр талаас нь хав халуун, нөгөө нь цэв хүйтэн рашаан ундардаг /Баянхонгор/, нойр муутай хүн уумагц нойр хүрдэг /Завхан/, эсвэл дэргэдүүр нь урсдаг татуургын усаар даруулж хүртдэг /Увс/, халуунаар нь хөлдүү шар тос хайлуулан хөвүүлж уудаг /Дорнод/, дэргэд нь маань хөгжөөхөд улам ундардаг /Говь-Алтай/ зэрэг үзэж хараагүй хүн үл үнэмшим, өвөрмөц удвист чанарт рашаан ударга ч цөөнгүй бий.

